



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2022-2023 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтад суралцагчдын сургалтын нэг кредитийн төлбөрийг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

2. Магистрантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.4 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

3. Докторантурын сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

4. Бизнесийн ахисан түвшний сургууль, Инженерийн ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын төвийн сургалтын нэг кредитийн төлбөрийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн дундаж үнэлгээг магистрантурт 1.4, докторантурт 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.


5. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

6. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэлээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн төлбөрийг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

7. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн төлбөрийг тооцохдоо энэхүү тогтоолын 1-6 дахь заалтуудын үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

8. 2022-2023 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 3.000.000 (гурван сая) төгрөгөөр, бүрэлдэхүүн ШУТИС-Коосен технологийн коллежийн сургалтын төлбөрийг 3.300.000 (гурван сая гурван зуун мянга) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 2.000.000 (хоёр сая) төгрөгөөр тогтоосугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13 -ны өдрийн 40 дугаар тогтоолын хавсралт



**ШУТИС-ИЙН 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
МӨРДӨХ НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ**

Д.Д	СУРГУУЛЬ	Хөтөлбөрийн ангилал	Нэг кредитийн үнэлгээ төгрөгөөр		
			2022/23 оны хичээлийн жилд элссэн оюутан	2019/20, 2020/21, 2021/22 оны хичээлийн жилд элссэн оюутан	2018/19 оны хичээлийн жил түүнээс өмнө элссэн оюутан
1	БАРИЛГА АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	Инженер, технологи	138,016	105,056	95,325
2	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
3	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
5	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		138,016	105,056	95,325
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ		138,016	105,056	97,616
7	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	Нийгмийн ухаан	134,976	102,742	100,416
8	ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ	Хэрэглээний шинжлэх ухаан	120,536	91,750	83,489
9	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		79,300	79,300	86,035
10	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ		120,536	91,750	87,689
	ДУНДАЖ		107,040		